



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах журмыг нэгдүгээр хавсралтаар, шалгаруулалтыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмын дагуу оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулж, жил бүрийн 12 дугаар сарын 2 дахь 10 хоногт багтаан танилцуулж байхыг Ажлын хэсгийн ахлагч, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Д.Даваадорж/-д даалгасугай.

3. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулж урамшуулахад гарах хөрөнгийг Ашигт малтмал, газрын тосны газрын жил бүрийн төсөвт суулгаж санхүүжүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Б.Баатарцогт/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаалтай холбогдуулан “Журам батлах тухай” Уул уурхайн сайдын 2012 оны 67 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Ц.ДАШДОРЖ

08 0170

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2016 оны 11 сарын 30-ны өдрийн  
А/З дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
ОНЫ ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ШАЛГАРУУЛАХ  
ЖУРАМ**

1116127151  
УХА0580 9129294

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Энэхүү журмын зорилго нь улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа, шинжилгээний ажлыг чанар, үр бүтээлтэй гүйцэтгэх, газрын тос, геологи-хайгуулын ажилд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шинээр ашигт малтмал, газрын тосны орд нээх, уул уурхайн олборлолт, баяжуулалт, боловсруулалтын болон хүнд үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, тэргүүний техник, технологи нэвтрүүлэх, нээлттэй, ил тод байх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдлыг урамшуулан дэмжихэд оршино.

1.3. Шилдэг аж ахуйн нэгж, байгууллагын шалгаруулалтад Монгол Улсын нутаг дэвсгэрт геологийн төрөл бүрийн судалгаа, эрэл, хайгуул, уул уурхайн олборлолт, баяжуулалт, боловсруулалт, хүнд үйлдвэр, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдана.

1.4. Шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар байгуулсан Ажлын хэсэг удирдан зохион байгуулж, санал, дүгнэлтээ яамны удирдлагад танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулна.

1.5. Шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга ахална.

1.6. Болзол хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг дараах номинациар жил бүр шалгаруулна:

- Геологийн судалгааны шилдэг байгууллага
- Геологи-хайгуулын шилдэг байгууллага
- Тэргүүний хөрөнгө оруулагч
- Шилдэг шинэ технологи нэвтрүүлэгч
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэгч
- Тэргүүний нөхөн сэргээгч
- Шилдэг зураг төсөл боловсруулагч
- Шилдэг туслан гүйцэтгэгч
- Шилдэг ханган нийлүүлэгч

1.7. Тухайн номинацид "Оны шилдэг"-ээр шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын гарын үсэгтэй батламж, дурсгалын зүйл гардуулж хадгалуулна.

## Хоёр. Шалгаруулах үзүүлэлт

- 2.1. “Геологийн судалгааны шилдэг байгууллага”-ыг шалгаруулах болзол:
  - 2.1.1. Геологийн салбарт чанартай, үр бүтээлтэй ажил гүйцэтгэсэн;
  - 2.1.2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төслийн ажлыг цаг хугацаанд нь чанарын өндөр төвшинд гүйцэтгэсэн;
  - 2.1.3. Орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан;
  - 2.1.4. Жил бүрийн төсвийн тодотгол, хээрийн ажлаар алдаа, зөрчилгүй ажилласан;
  - 2.1.5. Тухайн байгууллага, аж ахуйн нэгж мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал болон орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж ажилласан байдал;
  - 2.1.6. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомж, дүрэм, стандартыг мөрдлөг болгон ажилласан байдал.
- 2.2. “Геологи-хайгуулын шилдэг байгууллага”-ыг шалгаруулах болзол:
  - 2.2.1. Геологийн салбарт үр бүтээлтэй ажил гүйцэтгэсэн, шинээр орд нээсэн;
  - 2.2.2. Тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл, тайлангтогтсон хугацаанд хүлээлгэн өгч батлуулсан;
  - 2.2.3. Хайгуулын ажлын зардлын доод хэмжээг жил бүр бодитой баталгаажуулсан;
  - 2.2.4. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн;
  - 2.2.5. Мэргэжилтэй боловсон хүчин болон орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байдал /гадаадын хөрөнгө оруулалттай компани бол Монголын мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдлыг гол үзүүлэлт болгох/;
  - 2.2.6. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомж, дүрэм, стандартыг мөрдлөг болгон ажилласан байдал.
- 2.3. “Тэргүүний хөрөнгө оруулагч” аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах болзол:
  - 2.3.1 Хөрөнгө оруулалт татаж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэсэнбайдал;
  - 2.3.2 Уул уурхайн үйлдвэрлэлд бодитой бүтээн байгуулалт хийсэн байдал;
  - 2.3.3 Олборлох салбарын ил тод байдлын санаачилгад нэгдэн жил бүрийн тайлангаа гаргаж өгсөн байдал;
  - 2.3.4 Ашиглаж байгаа ордын дэд бүтэц, уурхайн тосгон, барилгабайгууламжийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байдал;
  - 2.3.5 Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх болон ажилтныг мэргэшүүлэх, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байдал;
  - 2.3.6 Орон нутаг, бүс нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр.
- 2.4. “Шилдэг шинэ технологи нэвтрүүлэгч” аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах болзол:
  - 2.4.1 Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай шинэлэг, дэвшилтэт техник, технологи нутагшуулсан байдал;
  - 2.4.2 Олборлох салбарын ил тод байдлын санаачилгад нэгдэн жил бүрийн тайлангаа гаргаж өгсөн байдал;
  - 2.4.3 Техник, технологийн шинэчлэлийг тогтмол хийж зардлыг бууруулсан байдал, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлсэн байдал.

2.5. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэгч” аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах болзол:

2.5.1 Үйлдвэрлэлийн жигд, найдвартай ажиллагаа, төлөвлөгөөт зорилтын биелэлт;

2.5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл ахуйг сайжруулах ажилд төлөвлөсөн ба зарцуулсан хөрөнгө, зардал;

2.5.3 Ажилтнуудын ахуйн байр, нийгмийн асуудлыг шийдсэн байдал;

2.5.4 Сургалтын материаллаг бааз;

2.5.5 Үйлдвэрлэлийн ослын болон ослоос шалтгаалсан нас баралтын давтамжийн коэффициент салбарын дунджаас бага байх, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлт өмнөх жилүүдийнхээс буурсан байх.

2.6. “Тэргүүний нөхөн сэргээгч” аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах болзол:

2.6.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу үйл ажиллагаа явуулсан эсэх;

2.6.2 Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэсэн байдал;

2.6.3 Байгаль орчныг хамгаалах зорилгоор мөнгөн хөрөнгө байршуулах журмыг хэрэгжүүлж байгаа байдал;

2.6.4 Урьд жилүүдэд байгаль орчны талаар хийж байсан ажлын талаарх орон нутгийн байгаль орчны байцаагчийн чанарын үнэлэлт, дүгнэлт, тодорхойлолт авсан байх.

2.7. “Шилдэг зураг төсөл боловсруулагч” аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах болзол:

2.7.1 “Уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах зааврын дагуу боловсруулсан байх бөгөөд геологийн үндсэн нөөц болон дагалдах эрдсийн тогтоогдсон нөөцийг хаягдал, бохирдол багатай, техник технологийг сонгож оновчилсон байх, нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах ажлын талаар тусгасан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэсэн байдал, зэргийг төслийн шийдэлд тусгасан байдал;

2.7.2 Ордыг ашиглах төслийг боловсруулахдаа эцсийн бүтээгдэхүүн гаргах, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг тухайн үеийн технологид тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлсэн байдал;

2.7.3 Орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны байгууллага, иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага болон иргэдтэй хамтран ажиллах, тэдний нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болох ажлыг тусгасан байдал;

2.7.4 Төсөл захиалагчаас гүйцэтгэгчид ирүүлсэн ямар нэгэн гомдол маргаангүй байх ба техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцүүлэн батлуулсны дараа Геологийн мэдээллийн төвийн нэгдсэн архивд журмын дагуу хүлээлгэж өгсөн байдал.

2.8. “Шилдэг туслан гүйцэтгэгч” аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах болзол:

2.8.1. Уул уурхай, геологи, газрын тосны салбарт мэргэжлийн ажил, үйлчилгээг үр бүтээлтэй гүйцэтгэсэн талаарх ажил гүйцэтгүүлэгчийн тодорхойлолт;

2.8.2. Тухайн мэргэжлийн ажил, үйлчилгээний жилийн гүйцэтгэл, үр дүн, тайланг хугацаанд нь чанарын өндөр төвшинд хүлээлгэн өгсөн байдал;

2.8.3. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, стандартыг мөрдөж осолгүй ажилласан байдал;

2.8.4. Мэргэжилтэй боловсон хүчин болон орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байдал /гадаадын хөрөнгө оруулалттай компани бол Монголын мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдлыг гол үзүүлэлт болгох/

2.8.5 Тухайн мэргэжлийн ажил, үйлчилгээг гүйцэтгэхдээ шинэ техник, технологи, тэргүүн туршлага нэвтрүүлсэн, дээд амжилт тогтоосон, олон улсын стандарт шаардлагыг хангасан байдал.

2.9. “Шилдэг ханган нийлүүлэгч” аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах болзол:

2.9.1 Тухайн захиалагч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломж, бололцоогоор найдвартай хангаж ажилласан байдал;

2.9.2 Хөрөнгө оруулалт бодитой байх;

2.9.3 Бараа, ажил, үйлчилгээний үнийн тогтвортой байдал;

2.9.4 Шинэ дэвшилтэт техник технологи, тэргүүн туршлага, эрүүл хүнс, аюулгүй орчныг бүрдүүлж нэвтрүүлсэн байдал;

2.9.5 Шинээр бий болгосон ажлын байр.

### **Гурав. Бүрдүүлж ирүүлэх материал**

3.1. Шалгаруулалтад оролцохыг хүссэн аж ахуйн, нэгж байгууллага дараах материалыг геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ:

3.1.1. Шалгаруулалтад оролцох тухай албан хүсэлт

3.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагын танилцуулга, илтгэх хуудас, холбогдох бусад нотлох баримт материал, видео бичлэг, фото зураг г.м.

3.1.3. Тухайн аймаг, дүүргийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын болон татварын байгууллага, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын албаны шалгаруулалтад оролцохыг дэмжсэн албан бичиг.

### **Дөрөв. Бусад**

4.1. “Геологийн судалгааны шилдэг байгууллага”, “Геологи-хайгуулын шилдэг байгууллага”, “Тэргүүний хөрөнгө оруулагч”, “Шилдэг шинэ технологи нэвтрүүлэгч”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэгч”, “Тэргүүний нөхөн сэргээгч”, “Шилдэг зураг төсөл боловсруулагч” “Шилдэг туслан гүйцэтгэгч”, “Шилдэг ханган нийлүүлэгч” гэсэн номинациар жил бүрийн 12 дугаар сарын 3 дахь арав хоногт багтаан Ажлын хэсэг шалгаруулалтыг зохион байгуулж, шагналыг гардуулна.

4.2. Шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах, шагнал гардуулахад гарах хөрөнгийг геологи, уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөвт суулган санхүүжүүлнэ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2016 оны 11 сарын 30-ны өдрийн  
А/63 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

УХА0580 9129294

Ажлын хэсгийн ахлагч:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Ажлын хэсгийн гишүүд:

- УУХҮЯ-ны Геологийн бодлогын газрын дарга
- УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга
- УУХҮЯ-ны Түлшний бодлогын газрын дарга
- УУХҮЯ-ны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга
- УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
- УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Ашигт малтмал, газрын тосны газрын орлогч дарга
- АМГТГ-ын Геологи, хайгуулын хэлтсийн дарга
- АМГТГ-ын Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтсийн дарга
- АМГТГ-ын Нүүрсний судалгааны хэлтсийн дарга
- АМГТГ-ын ГХХ-ийн Ашигт малтмалын хайгуул хариуцсан ахлах мэргэжилтэн
- АМГТГ-ын ГХХ-ийн Геологийн дунд масштабын зураглал хариуцсан мэргэжилтэн
- АМГТГ-ын ГХХ-ийн Газрын тосны хайгуул хариуцсан мэргэжилтэн
- АМГТГ-ын УУҮТХ-ийн Үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- АМГТГ-ын УУҮТХ-ийн Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, зах зээлийн судалгаа хариуцсан мэргэжилтэн
- АМГТГ-ын УУҮТХ-ийн Уул уурхайн салбарын хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны судалгаа хариуцсан мэргэжилтэн
- АМГТГ-ын УУҮТХ-ийн Техник, эдийн засгийн үндэслэл, хэтийн төлөв, ЭБМЗ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- АМГТГ-ын Хүнд үйлдвэрийн техник, технологийн хэлтсийн Ашигт малтмалын боловсруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

- УУХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

---- оОо ----